

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дамбаринчен	Дугаар	L096
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Галшир сум
Төрсөн газар	Галшар сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зүүн Ганжуурын хийд, Рашаантын хурал, Хардэлийн ганжуур, Хужиртын хийд	Сүм хийдийн дугаар	ХЭГЛ 053, ХЭГЛ 049, ХЭГЛ 046, ХЭГЛ 054
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 23	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Хэнтий аймгийн Галшар сумын Зүүн Ганжуурын хийд, Рашаантын хурал, Хардэлийн ганжуур, Хужиртын хийд

-Зүүн Ганжуурын хийд гэдэг нь хаана байдаг юм бэ?

Галшараас баруун хойно.Баянханы зүүнхэн талд байдаг.

- Цанын ганжуурын хийд гэдэг нь хаана байсан юм бол?

Мэдэхгүй. Тэрийг зүүн чигийхэн л Сант чигийнхэн, Баян-Өлзийтийнхэн л мэдэх байх.

-Зодын хурал гэж байсан байна.

Сумын төвийн зүүн хаданд бий.

Туурь нь мэдэгдэх үү?

Мэдэгдэнэ биз дээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Зодын хурал гэдэг нь Галшар уул гэж тэмдэглэгдсэн байна?

Галшарын Зодын хурал гэдэг нь уулын баруун хойд талд Зодын хурал гэж байсан юм. Буянтын зодын хурал хадан дотор байсан.

-Хурын сүм гэж тэмдэглэсэн байсан. Сангийн далайн худаг гэдэг газар тэмдэглэсэн байна.

Тэнд хурал байсан юм байх даа. Тэнд нэг жаахан хурал байсан байхаа. Хүн тайжийн хурал гэж байсан. Хүрийн сүм гэдэг чинь Сангийн далайн хурал гэдэг газар байсан.

-Рашаантын хурал гэж хаана байсан юм бэ? Айраг нуурын тэнд байсан гэж байна? Ганданшадавдаржаалин гэдэг нэртэй байсан байх юм. Энэ Хужиртын хурал байж болох уу?

Мөн дөө. Баруун урд байгаа байх. Тэнд хийдтэй болсон. Хуучин Галшарын хурал гэж Чойртой 4 аймагтай, Жүдтэй айхтар хурал байсан. Хамгийн толгой хурал нь байсан.

Галшарын хурал гэдэг нь Хужиртын хурлаа хэлж байгаа юм уу?

Тийм.

-Хунтайжийн ганжуур гэж байна. Үнээт нуурын энд.

Үнээгийн улааны баруухан хойно нь байсан байхаа. Үнээгээс ийшээ нэг нуур байсан. Одоо бол усгүй.

-Цанын ганжуур нь Үнээн нуураасаа хаашаа юм?

Энэ зүүн тийшээ юм. Өлзийт эд нар бол мэднэ.

-Буянт сумын Хардэлийн ганжуур гэж?

Одоо энд бага Хардэлийн Ганжуур гэж байсан. Энэ Ганжуур чинь бас шатсан юм. Тэгээд сахиус нь нүүрсэн дороосоо гарсан гэж байгаа. Чүлтэм гэдэг хүн тэрийг олж авсан гэсэн. Тэр хүн эзэмшиж олж авчихаад сүүлд Энхээ гэдэг хүн хадгалж байсан. Лхам сахиустай байсан.

-Буянтын Ганжуур гэдэг газар сая шав тавьсан юмуу?

Тийм.

-Өөр энэ дээр гараагүй хийд байна уу?

Байхгүй байхаа. Гарьдын зодын хурал гэж байсан. Зүүн хадан дотор байсан даа. Малын нядалгаа хийж байсан.

-Та Галшарын Хужиртын хийдэд сууж байсан уу?

Тийм жаахан байсан. Багшийн дэргэд л сууж байдаг байсан.

-Галшарын хийд ямар хуралтай байсан бэ?

Чойр эргэдэг. Цорж энэ тэр гээд олон хэргэм хүртээж байсан. Жүдийн хурал гэж баруун урд нь байсан. Ганц хүн очиж санг нь тавьдаг жодын хурал байсан.

-Та өөрөө аль дацанд нь голлон сууж байсан бэ?

Би дацанд сууж байгаагүй ээ. Зүгээр аймагт очиж хуралд сууж байсан.

-Цогчэн хурал хүрж байсан юм уу?

Тийм. Аймагт бол Ишдоо, Гэндэнжамц нар бий. Эд нараас сайн асуу. сурна. Хуралд оролцож байсан тийм хүмүүс бий.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Галшарт энд гараагүй өөр хурал байна уу?

Байхгүй. Хууччуул байхгүй болж дээ.